



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 64

Сангийндалай

Хоршоог хөгжүүлэх сангийн төсөл
сонгон шалгаруулах хороог шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталж, 2022 оны А/243 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 3 дугаар зүйлийн 3.3.2 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь :

1. Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл сонгон шалгаруулах хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хорооны дарга: Г.Энхдэлгэр / Сумын Засаг даргын Тамгын газрын дарга/

Нарийн бичгийн дарга: Б.Нандинцэцэг /Хоршоо, ЖДҮ хариуцсан мэргэжилтэн/

Гишүүд: Т.Энхбат / Санхүү, төрийн сангийн нягтлан бодогч/

С.Оюунчимэг /Баялаг бүтээгчдийн холбооны гишүүн/

Ц.Чинбат /Төрийн бус байгууллагын төлөөлөл/

2. Төслийг журмын дагуу сонгон шалгаруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулахыг хорооны дарга (Г.Энхдэлгэр) –т үүрэг болгосугай.

3. 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 48 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.



ДАРГА

Н.ЧУЛУУН



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 65

Сангийндалай

Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих, хяналтын зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталж, 2022 оны А/243 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 3 дугаар зүйлийн 3.3.2 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих, хяналтын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: С.Мөнхбаатар /Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч/

Нарийн бичгийн дарга: Б.Нандинцэцэг /Хоршоо, ЖДҮ хариуцсан мэргэжилтэн/

Гишүүд: Ж.Бадамцэцэг /Төрийн сангийн мэргэжилтэн/

Ж.Хишигсүрэн /ЗДТГ-ын нягтлан бодогч /

Я.Бат-Өлзий /Төрийн бус байгууллагын төлөөлөл/

2. Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд журмын дагуу хяналт хийж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулахыг зөвлөлийн дарга (С.Мөнхбаатар) –т үүрэг болгосугай.

3. 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 49 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА



Н.ЧУЛУУН



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 66

Сангийндалай

Хоршоог хөгжүүлэх сангаас олгох зээлийн
дээд хэмжээнд нэмэлт өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 А/361 дүгээр тушаалаар баталж, 2022 оны А/243 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 1 дүгээр зүйлийн 1.5 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хоршоог хөгжүүлэх сангаас нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг жижиг дунд үйлдвэр эрхлэгчид 100,000,000 (нэг зуун сая) хүртэл төгрөгөөр, иргэний төсөлд 20,000,000 (хорин сая) хүртэл төгрөг байхаар тогтоосугай.
2. Зээл олгох үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулж, сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулахыг Засаг дарга (Б.Лхагвамандал)-д, сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллахыг хяналтын зөвлөлийн дарга (С.Мөнхбаатар) нарт тус тус үүрэг болгосугай.



ДАРГА *Н.Чулуун* Н.ЧУЛУУН

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 05 сарын 30-ны өдрийн
50 дугаар тогтоолын хавсралт

Хоршоог хөгжүүлэх сангаас зээл олгоход
баримтлах чиглэл

№	Салбар	Чиглэл
1	Хүнсний үйлдвэрлэл	<ul style="list-style-type: none">• Сүү сүүн бүтээгдэхүүн• Талх, нарийн боов, гурилан бүтээгдэхүүн• Малын дайвар бүтээгдэхүүн боловсруулах, худалдаалах• Хоол үйлдвэрлэл
2	Хөнгөн үйлдвэрлэл	<ul style="list-style-type: none">• Төмөр эдлэл үйлдвэрлэл• Оёдол, эсгүүр үйлдвэрлэл• Гутал үйлдвэрлэл• Модон эдлэл (мужаан гэрийн тавилга)• Сүлжмэл, нэхмэл, ноос ноолууран эдлэл• Хог хаягдал, ангилан ялгалт, дахин боловсруулах
3	Газар тариалан	<ul style="list-style-type: none">• Төмс, хүнсний ногоо• Мод үржүүлэг, жимс жимсгэнэ тариалах• Хүлэмжийн аж ахуй• Тэжээлийн ургамал тариалах• Эмийн ургамал тариалах
4	Хөдөө аж ахуй	<ul style="list-style-type: none">• Арьс шир боловсруулах• Эсгий эдлэл• Мал үржлийн ажил үйлчилгээ,• Мал эмнэлгийн ажил үйлчилгээ• Гахай, шувууны туслах аж ахуй• Мах боловсруулах
5	Барилга	<ul style="list-style-type: none">• Блок, тоосго, замын өнгөт хавтан үйлдвэрлэл• Зөөврийн сууц, хашаа хийц
6	Үйлчилгээ	<ul style="list-style-type: none">• Үсчин, гоо сайхан• Авто засвар, дугуй засвар, гагнуур• Техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ• Гутал засварын үйлчилгээ• Зочид буудлын үйлчилгээ• Аялал жуулчлал, жуулчны бааз
7		<ul style="list-style-type: none">• Түгээмэл тархац олборлох үйл ажиллагаа